



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/634

Хэрлэн сум

- Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний санхүүжих дүнд зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралт, Засгийн газрын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 10 дугаар сарын 10-ны 366 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны “Эрх шилжүүлэх тухай” 267 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны “Эрх шилжүүлэх тухай” 267 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар эрх шилжиж ирсэн “Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон)” төсөл, арга хэмжээний багцуудын 2022 оны санхүүжих дүнд хийх зохицуулалтыг хавсралтаар баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын
 2022 оны 12 дугаар сарын 15-ний
 А/БС... дугаар захирамжийн хавсралт



Багцын дугаар	Багцын нэр	Төсөвт өртөг (төгрөг)	2022 оны санхүүжилт (төгрөг)	Өөрчлөлт	Зохилцуулалт хийсэн 2022 оны санхүүжих дүн
Багц 1	Сумын төвийн цэвэр усны хангамжийн байгууламж (Хэнтий, Баянхутаг сум), Усан хангамжийн байгууламж, шугам сүлжээ (Хэнтий, Дэлгэрхаан сум), Усан хангамжийн байгууламж, шугам сүлжээ (Хэнтий, Мөрөн сум)	1,088,000,000.0	448,200,000.0	0	448,200,000.0
Багц 2	Сумын төвийн усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Баян-Адларга сум), Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Норовлин сум), Цэвэрлэх байгууламж (Хэнтий, Цэнхэрмандал сум)	5,972,800,000.0	2,459,700,000.0	694,954,012.0	3,154,654,012.0
Багц 3	Сумын төвийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Баян-Овоо сум), Сумын төвийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Дадал сум)	1,776,704,250.0	731,500,000.0	0	731,500,000.0
Багц 4	Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж (Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон)	2,225,895,750.0	916,800,000.0	694,954,012.0	221,845,988.0